



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/34

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 05 дугаар зөвлөмжийн дагуу Арвайхээр сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг 47.499.999 (дөчин долоон сая дөрвөн зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн ес) төгрөгөөр Криетивмонголиа ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулж зураг төсөв боловсруулах явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

012100101

D: My Doc. Tushaal. ZDTG